



“БАРИЛГА” ХК-ИЙН  
УДИРДЛАГАД

## ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн  
хөндлөнгийн ханалтын байгууллага

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол  
Ногоон нуур тутамж, 101 барилгын 908 тоот  
Утас: (976) 99055711, 99038602, 70005711  
E-mail: dulguuinhairhan\_audit@mongol.net

2019.03.20 № 19/2-34

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

##### Зөрчилгүй дүгнэлт

Бид “Барилга” ХК-ийн /цаашид “Компани” гэх/ 2018 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Барилга” ХК-ийн 2018 оны 12 сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагынхаа энэхүү аудитын тайлангийнхаа Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Нягтлан бодогчдын ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлох зүйл нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

##### Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно. Тус компани нь цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэсэн төсөөллөөр тайлангаа бэлтгэсэн байна.

##### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргааүй болно.

##### Санхүүгийн тайланд засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлалгналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх,



толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, компания татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

#### **Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний үүрэг, хариуцлага бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олон явах гаримуудыг гүйцэтгэх ажил орно. Аудитын явцад компанил хэрэглэгчдэд байгаяа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлануудын бодитуй эсэлэд үзүүлэлт өгөв.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болон хувьцаа эзэмшигчийн хүснэгтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү Аудитын ажлыг хийж гүйцэтгэж аудитын тайланг бэлтгэсэн болно.



Б.ПУРЭВДУЛАМ  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 сарын 31-ний байдлаар

	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31	(төгрөгөөр)
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	981,774,633.18	2,026,651,600.05	
Авлага	3,628,644,867.66	2,604,452,956.33	
Бусад санхүүгийн хөрөнгө			
Бараа материал	205,585,139.12	35,113,164.49	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,268,110,762.49	2,577,878,073.01	
Бусад эргэлтийн хөрөнгө			
Бусад			
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>6,084,115,402.45</b>	<b>7,244,095,793.88</b>	
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	5,645,245,259.47	5,431,011,775.02	
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө			
Биет бус хөрөнгө	1,080,000.00	540,000.00	
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>5,646,325,259.47</b>	<b>5,431,551,775.02</b>	
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,730,440,661.92</b>	<b>12,675,647,568.90</b>	
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>Өр төлбөр</b>			
Богино хугацаат өр төлбөр	1,258,423,602.14	921,074,743.76	
Урт хугацаат өр төлбөр			
<b>Нийт өр төлбөр</b>	<b>1,258,423,602.14</b>	<b>921,074,743.76</b>	
<b>Эздийн өмч</b>			
Дүрмийн сан	2,500,713,000.00	2,500,713,000.00	
Халаасны хувьцаа			-
Нэмжк төлөгдсөн капитал			-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	827,962,633.48	827,962,633.48	
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц			-
Эздийн өмчийн бусад хэсэг			-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	7,143,341,426.30	8,425,897,191.66	
<b>Нийт эздийн өмч</b>	<b>10,472,017,059.78</b>	<b>11,754,572,825.14</b>	
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ДҮН</b>	<b>11,730,440,661.92</b>	<b>12,675,647,568.90</b>	

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2018 оны 12 сарын 31-ний байдлаар

	(төгрөгөөр)	
	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	10,033,897,072.10	12,493,950,749.09
Борлуулалтын өртөг	7,203,057,100.45	9,733,593,036.82
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>2,830,839,971.65</b>	<b>2,760,357,712.27</b>
Бусад орлого	442,370.00	-
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	2,315,712,708.40	889,079,669.35
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	-	-
Бусад олз (гарз)	(31,124,546.43)	(15,479,675.53)
Бусад ашиг (алдагдал)	(69,233,055.20)	(357,651,397.74)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>415,212,031.62</b>	<b>1,498,146,969.65</b>
Орлогын татварын зардал	44,237.00	187,127,804.29
<b>Татвар дараах ашиг (алдагдал)</b>	<b>415,167,794.62</b>	<b>1,311,019,165.36</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>415,167,794.62</b>	<b>1,311,019,165.36</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		
<b>Орлогын нийт дүн</b>	<b>415,167,794.62</b>	<b>1,311,019,165.36</b>
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Нэмэлт тодруулгүүф нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болжна.

